

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/129/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.4 Материаллаг байдал.....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа.....	20
4.2 Төлбөрийн акт	20
4.3 Албан шаардлага.....	20
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
			/төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>56,768,762.20</u>	<u>75,454,581.09</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	56,768,762.20	75,454,581.09
351	Түүхий эд материал	00.00	98,400.00
35130	Эм боох материал	00.00	98,400.00
354	Хангамжийн материал	55,238,762.20	73,826,181.09
35410	Бичиг хэргийн материал	992,450.00	1,420,650.00
35420	Аж ахуйн материал	52,226,669.60	69,314,040.49
35460	Хүнсний материал	938,980.00	2,010,828.00
35470	Бусад хангамжийн материал	1,080,662.60	1,080,662.60
35600	Мал амьтад	1,530,000.00	1,530,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,713,032,903.51</u>	<u>1,809,720,528.38</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,713,032,903.51	1,809,720,528.38
392	Биет хөрөнгө	1,683,832,903.51	1,780,520,528.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,686,687,232.41	1,794,312,875.41
39202	Хуримтлагдсан элэгдэл	-54,364,261.80	-82,475,715.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	138,527,500.00	150,587,158.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-125,920,695.83	-130,968,556.29
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,063,757.62	63,659,757.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37,056,852.00	-39,574,577.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,944,750.00	14,944,750.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,533,749.78	-8,443,750.13
39217	Ном	17,485,222.89	18,478,586.37
393	Биет бус хөрөнгө	29,200,000.00	29,200,000.00
39301	Програм хангамж	670,000.00	670,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-670,000.00	-670,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	29,200,000.00	29,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,769,801,665.71</u>	<u>1,885,175,109.47</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.01</u>	<u>994,723.15</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.01	994,723.15
413	Өглөг	00.01	994,723.15
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.01	994,723.15
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,769,801,665.70</u>	<u>1,884,180,386.32</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,769,801,665.70	1,884,180,386.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	393,366,267.38	393,366,267.38
51101	Өмч: - төрийн	393,366,267.38	393,366,267.38
512	Хуримтлагдсан үр дүн	-25,480,912.52	88,897,808.10
51210	Өмнөх үеийн үр дүн	-25,480,912.52	-25,480,912.52
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	114,378,720.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,401,916,310.84	1,401,916,310.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,769,801,665.71</u>	<u>1,885,175,109.47</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	613,830,826.50	761,021,560.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,788,226.50	282,732,175.37
120	Нийтлэг татварын бус орлого	4,788,226.50	143,497,475.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,900,476.50	143,497,475.37
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,900,476.50	143,497,475.37
120009	Бусад орлого	887,750.00	00.00
122	Тусламжийн орлого	00.00	139,234,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	143,652,500.00	33,129,285.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	4,300,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	4,300,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	465,390,100.00	445,160,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,280,800.00	28,829,285.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,280,800.00	28,829,285.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	139,371,700.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	139,371,700.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	647,514,928.86	646,642,839.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	647,514,928.86	646,642,839.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	601,305,142.36	616,679,254.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	368,935,227.69	369,076,054.72
210101	Үндсэн цалин	249,333,836.33	250,117,523.14
210102	Нэмэгдэл	87,623,403.36	83,160,429.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,921,599.00	11,590,916.67
210104	Урамшуулал	23,056,389.00	24,207,185.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,303,396.77	49,621,137.39
210201	Тэтгэврийн даатгал	32,698,209.56	34,922,081.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,214,179.08	3,673,550.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,274,666.11	2,938,006.60
210204	Ажилгүйдлийн даатгал	341,378.29	737,502.28
210205	Эрүүл мэндийн даатгал	6,774,963.73	7,349,996.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,381,406.75	137,897,340.95
210301	Гэрэл, цахилгаан	5,323,055.00	5,651,277.00
210302	Түлш, халаалт	120,058,351.75	132,246,063.95
2104	Хангамж, бараа материалын зардал	4,635,550.00	2,326,840.00
210401	Бичиг хэрэг	1,087,100.00	337,000.00
210402	Тээвэр, шатахуун	663,150.00	689,040.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	650,000.00	720,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,559,000.00	484,800.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	580,300.00	00.00
2105	Нормативт зардал	13,069,059.40	17,719,442.00

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	381,600.00
210502	Хоол, хүнс	12,120,759.40	16,162,302.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	948,300.00	1,175,540.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	266,000.00	220,000.00
210702	Дотоод албан томилолт	266,000.00	220,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	773,100.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	168,300.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,941,401.75	38,818,439.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,000.00	857,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	613,700.00	373,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,252,701.75	37,587,039.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,209,786.50	29,963,585.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,205,800.00	29,656,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	10,666,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,280,800.00	18,104,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	925,000.00	886,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,906,793.25	137,359.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,906,793.25	137,359.05
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,097,193.25	169,626.03
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,097,193.25	169,626.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-33,684,102.36	114,378,720.62
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-33,684,102.36	114,378,720.62

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	393,366,267.38	1,401,916,310.84	9,290,942.14	1,804,573,520.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-34,771,854.66	-34,771,854.66
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	393,366,267.38	1,401,916,310.84	-25,480,912.52	1,769,801,665.70
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	393,366,267.38	1,401,916,310.84	-25,480,912.52	1,769,801,665.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	393,366,267.38	1,401,916,310.84	-25,480,912.52	1,769,801,665.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	114,378,720.62	114,378,720.62
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	393,366,267.38	1,401,916,310.84	88,897,808.10	1,884,180,386.32

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	609,042,600.00	617,524,085.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	139,234,700.00
122	Тусламжийн орлого	00.00	139,234,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	609,042,600.00	478,289,385.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	4,300,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	4,300,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	465,390,100.00	445,160,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,280,800.00	28,829,285.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,280,800.00	28,829,285.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	139,371,700.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	139,371,700.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	609,042,600.00	617,524,085.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	609,042,600.00	617,524,085.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	558,686,033.50	579,577,797.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	368,935,227.69	367,581,531.58
210101	Үндсэн цалин	249,333,836.33	248,623,000.00
210102	Нэмэгдэл	87,623,403.36	83,160,426.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,921,599.00	11,590,916.67
210104	Урамшуулал	23,056,389.00	24,207,188.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,303,399.06	49,621,137.39
210201	Тэтгэврийн даатгал	32,698,209.56	34,922,081.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,214,181.37	3,673,550.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,274,666.11	2,938,006.23
210204	Ажилгүйдлийн даатгал	341,378.29	737,502.65
210205	Эрүүл мэндийн даатгал	6,774,963.73	7,349,996.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,464,906.75	138,097,340.95
210301	Гэрэл, цахилгаан	5,323,055.00	4,797,965.00
210302	Түлш, халаалт	120,141,851.75	133,099,375.95
210303	Цэвэр, бохир ус	00.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,283,650.00	3,776,040.00
210401	Бичиг хэрэг	329,700.00	365,100.00
210402	Тээвэр, шатахуун	579,650.00	489,040.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	650,000.00	465,000.00
210404	Ном, хэвлэл	285,000.00	298,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	119,800.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,319,500.00	1,998,900.00
2105	Нормативт зардал	8,474,840.00	12,565,348.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	94,000.00	490,000.00

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	7,232,440.00	9,285,648.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,148,400.00	2,789,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	176,000.00	220,000.00
210702	Дотоод албан томилолт	176,000.00	220,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	580,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	580,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,468,010.00	6,716,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,000.00	1,387,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,368,010.00	5,328,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,356,566.50	37,946,287.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,352,580.00	37,639,302.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,151,780.00	7,982,702.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	10,666,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,280,800.00	18,104,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,000.00	886,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,906,793.25	137,359.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,906,793.25	137,359.05
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,097,193.25	169,626.03
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,097,193.25	169,626.03
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	597,646,400.0	584,087,899.9	13,558,500.1	97.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	597,646,400.0	584,087,899.9	13,558,500.1	97.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	584,459,400.0	575,219,197.9	9,240,202.1	98.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	367,582,700.0	367,581,531.6	1,168.4	100.0
210101	Үндсэн цалин	248,623,000.0	248,623,000.0	-	100.0
210102	Нэмэгдэл	82,872,300.0	83,160,426.4	(288,126.4)	100.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,880,000.0	11,590,916.7	289,083.3	97.6
210104	Урамшуулал	24,207,400.0	24,207,188.5	211.5	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,623,200.0	49,621,137.4	2,062.6	100.0
210201	Тэтгэврийн даатгал	37,039,000.0	34,922,081.0	2,116,919.0	94.3
210202	Тэтгэмжийн даатгал	3,156,700.0	3,673,550.8	(516,850.8)	116.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,514,000.0	2,938,006.2	(424,006.2)	116.9
210204	Ажилгүйдлийн даатгал	628,500.0	737,502.7	(109,002.7)	117.3
210205	Эрүүл мэндийн даатгал	6,285,000.0	7,349,996.7	(1,064,996.7)	116.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,206,700.0	138,097,341.0	9,109,359.1	93.8
210301	Гэрэл, цахилгаан	6,134,700.0	4,797,965.0	1,336,735.0	78.2
210302	Түлш, халаалт	140,872,000.0	133,099,376.0	7,772,624.1	94.5
210303	Цэвэр, бохир ус	200,000.0	200,000.0	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,795,000.0	3,717,440.0	77,560.0	98.0
210401	Бичиг хэрэг	350,000.0	306,500.0	43,500.0	87.6
210402	Тээвэр, шатахуун	500,000.0	489,040.0	10,960.0	97.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.0	465,000.0	35,000.0	93.0
210404	Ном, хэвлэл	285,000.0	298,000.0	(13,000.0)	104.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.0	160,000.0	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.0	1,998,900.0	1,100.0	99.9
2105	Нормативт зардал	12,599,800.0	12,565,348.0	34,452.0	99.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.0	490,000.0	10,000.0	98.0
210502	Хоол, хүнс	9,299,800.0	9,285,648.0	14,152.0	99.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,800,000.0	2,789,700.0	10,300.0	99.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.0	1,000,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	1,000,000.0	1,000,000.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	223,000.0	220,000.0	3,000.0	98.7
210702	Дотоод албан томилолт	223,000.0	220,000.0	3,000.0	98.7

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,400,000.0	-	1,400,000.0	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,400,000.0	-	1,400,000.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,029,000.0	2,416,400.0	(1,387,400.0)	234.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,029,000.0	1,028,800.0	200.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,187,000.0	8,868,702.0	4,318,298.0	67.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,187,000.0	8,868,702.0	4,318,298.0	67.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,986,500.0	7,982,702.0	3,798.0	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,280,000.0	-	4,280,000.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	920,500.0	886,000.0	34,500.0	96.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	593,336,300.0	584,394,800.0	8,941,500.0	98.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	445,160,100.0	445,160,100.0	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	445,160,100.0	445,160,100.0	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	148,176,200.0	139,234,700.0	8,941,500.0	94.0
132001	Орон нутгийн төсвөөс	148,176,200.0	139,234,700.0	8,941,500.0	94.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	30.0	30.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	19.0	19.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	10.0	10.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,829,285.00	28,829,285.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,829,285.00	28,829,285.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,829,285.00	28,829,285.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,829,285.00	28,829,285.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,725,085.00	10,725,085.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,104,200.00	18,104,200.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,829,285.00	28,829,285.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,829,285.00	28,829,285.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,829,285.00	28,829,285.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, хөрөнгө, бараа материалыг зөв ангилан бүртгэж байх, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь танхимын болон танхимын бус хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, суралцагчдыг хоцрогдолгүй сургах талаар бүх талын хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллахыг зорилгоо болгон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын баг нь 2021 оны ажлын төлөвлөгөө гарган, дотоод хяналтын нэгжийн тайлангаа улирал бүр тайлагнаж ажилласан.

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг. Тайлант онд Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны төлөвлөгөөний дагуу 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 593,336.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,900.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,675.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 593,336.3 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 584,394.8 мянган төгрөгийн санхүүжилтийг 98.5 хувьтай авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 28,829.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 613,165.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 107,625.6 мянган төгрөгийн барилга байгууламж, 12,059.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 13,596.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 993,4 мянган төгрөгийн ном, нийт 134,274.7 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 4,677.8 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 129,596.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 13,900.6 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 24,209.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 19,423.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлагын үлдэгдэлгүй, 994.7 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Энэ нь ажиллагсадтай холбоотой ХХОАТ-ын өглөг байна. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 75,454.6 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,809,720.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	56,768.8	75,454.6	18,685.8
Үндсэн хөрөнгө	1,713,032.9	1,809,720.5	96,687.6
Нийт хөрөнгө	1,769,801.7	1,885,175.1	115,373.5
Өр төлбөр	-	994.7	994.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,769,801.7	1,884,180.4	114,378.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,769,801.7	1,885,175.1	115,373.5

Бараа материалын дансны үлдэгдэл 75,454.6 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 18,685.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,809,720.5 мянган төгрөг болж 96,687.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,884,180.4 мянган төгрөг болж 114,378.7 мянган төгрөгөөр өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 593,336.3 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 584,429.3 мянган төгрөг, татаас ба урсгал шилжүүлгийн зардалд 8,907.0 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 584,429.3 мянган төгрөгийн урсгал зардал, 8,907.0 мянган төгрөгийн татаас ба урсгал шилжүүлгийн зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 584,394.8 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 584,087.9 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 306.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 584,084.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 28,829.3 мянган төгрөг төвлөрч, урсгал шилжүүлэгт 28,829.3 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 107,625.6 мянган төгрөгийн барилга байгууламж, 12,059.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 13,596.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 993,4 мянган төгрөгийн ном, нийт 134,274.7 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 4,677.8 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 129,596.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны эцэст 1,809,720.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 75,454.6 мянган төгрөгийн бараа материалын тооллогын үр дүнг хэлэлцэж баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 145,127.8 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж данс бүртгэлд тусгаагүй, бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй 9,502.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэж тайлагнасан зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, УСНББОУС 12 Бараа материал, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгөд нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Оршин байх", "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс 133 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 6 мэдээллийг хугацаа хоцроож, 7 мэдээллийг мэдээлээгүй төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 санхүүгийн тайланд аудит хийх явцад 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, холбогдох нотлох дэмжих баримт материалаа хуулийн хугацаа хоцроон аудитын байгууллагад ирүүлсний улмаас цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл үүсэж, бараа материалтай холбоотой түүний дотор мал амьтдын бүртгэлийг нягтлаагүй тул дараагийн аудитаар нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 156,975.4 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 212.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 156,762.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 212.9 мянган төгрөгийн 1 алдааг залруулав. Үүнд:

1. Дэлхийн зөн Монгол ОУБ-аас Орон нутгийн хөтөлбөр 2021 хүрээнд үнэ төлбөргүй олгосон 212.9 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж тайлагнаагүй нь: НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Оршин байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй болно.

4.3 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Захирлын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/11 дүгээр “Комисс байгуулах тухай” тушаалаар үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг 2021 оны жилийн тооллого явуулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, хөрөнгийн тооллогыг гүйцэтгэсэн боловч тооллогын үр дүнг хэлэлцээгүй, баталгаажуулаагүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-д “Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Оршин байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн хөрөнгийн тооллогыг бодитой гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 131 нэр төрлийн 145,127.8 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд 19 нэр төрлийн 9,502.8 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн шинжтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 273 дугаар тогтоол, УСНББОУС 12-той тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө, бараа материалыг зөв ангилан бүртгэх

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант онд 1 албан хаагчийн 937.2 мянган төгрөгийн цалинг НДШ төлөлтийн тайланд дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтыг үндэслэн холбогдох тайлан мэдээг үнэн зөв тайлагнаж байх

4. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 1 нэр төрлийн 200.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн биет бус хөрөнгийг шийдвэрлүүлэх

5. Балансын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Тайлант оны эцэст ажилчидтай холбоотой 994.7 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, өглөгийн даруй барагдуулах

6. Шилэн данстай холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 133 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 6 мэдээллийг хугацаа хоцроож, 7 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"

гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль	8	156,975.4	1	212.9	-	-	1	-	6	156,762.5

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn